



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бат-Өлзийн БАТ-ЭРДЭНЭ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-29-79, Факс: 32-70-16
E-mail: baterdene.b@parliament.mn
http: //www.parliament.mn

2025.06.19 № 442-03/7585
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадгаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон Нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.БАТ-ӨРДЭНЭ
О.АМГАЛАНБААТАР
Б.БАТБААТАР
Ж.БАТЖАРГАЛ
С.ЗАМИРА
С.ЛҮНДЭГ
М.МАНДХАЙ
Б.НАЙДАЛАА
М.НАРАНТУЯА-НАРА
С.ОДОНТУЯА
М.САРНАЙ
С.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Бат-Өлзийн БАТ-ЭРДЭНЭ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-29-79, Факс: 32-70-16
E-mail: baterdene.b@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.12 № 447-03/7273
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов
тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, дэлгэрэнгүй танилцуулга, хуулийн төслийг хавсаргав.

Хавсралт 10. хуудастай


Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.БАТ-ЭРДЭНЭ



БАТЛАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  Б.БАТ-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хоринтавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”, Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус зааж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэх, ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үндэснийхээ эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчимд үндэслэхийг Үндсэн хуулиараа тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажиллана.” гэж, 22.3 дахь хэсэгт Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээний бүрэн эрхийг, 22.6 дахь хэсэгт Улсын Их Хурал 11 Байнгын хороог, мөн хуулийн 23 дугаар зүйлээр Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээг заасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлээр Дэд хорооны асуудлыг зохицуулсан байх бөгөөд 27.3 дахь хэсгийн 27.3.1-д Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын, 27.3.2-т Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, 27.3.3-т Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын, 27.3.4-т Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн, 27.3.5-д Эдийн засгийн байнгын хороонд Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог Байнгын хорооны бүрэлдэхүүнд байгуулахаар зааж, мөн зүйлийн 27.5 дахь хэсгээр дэд хорооны эрхлэх асуудлыг тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1 дүгээр хавсралтын Хүнд ээлтэй амьдрах орчин зорилтын 2.2 хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ын 2-т “Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчинтой болно” гэж, Орчин төвтэй шийдэл зорилтын 9.2 хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ын 2-т “Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна” гэж, 4-т “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх

бохирдлыг бууруулсан байна” гэж, 4-т “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна” гэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т заасны дагуу 70,000 ба түүнээс дээш тооны иргэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах санал гаргаж, хуульд заасан журмын дагуу шаардлага, нөхцөл хангагдсан тул Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2025 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдөр зохион байгуулж, санал, дүгнэлтээ 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн БОХХААБХ-нд, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы Нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүнэлтэд “Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид утаа, агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулж, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, хянан шалгах эрх бүхий байгууллагын мэдээллийг тогтмол сонсох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх” гэж тусжээ.

1.2.Практик шаардлага

“Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн үндсэн хуулийн заалт нь Улсын Их Хурлаас нийтийн эрх ашигт хамаарах аливаа асуудлыг шийдвэрлэхэд Улсын Их Хурлын гишүүд зөвхөн тойргийнхоо эрх ашгийг бус, нийт улсын эрх ашгийн үүднээс асуудалд хандах зарчмаар илэрхийлэгддэг бөгөөд энэ хүрээнд Агаар, орчны бохирдлын талаар хууль тогтоох байгууллагын түвшинд холбогдох хуулиар зохицуулж байсан харилцааг судлахад:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг нь анх 1992 онд баталж, 1997, 2001, 2006, 2020, 2024 онуудад шинэчилэн найруулсан байна. Дээрх онуудад батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын Байнгын хороо, дэд хорооны асуудлыг хэрхэн хуульчилж байсан талаар товч дурдвал,

1992 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн анхдагч хуулийг баталсан байх бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.” гэж, 13 дугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, мөн зүйлийн 2-т “Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар,

чиглэлээр байгуулах бөгөөд дараах Байнгын хороотой байна” гээд 10 Байнгын хороог нэрлэн заажээ. Тухайлбал, “1/Байгаль орчныг хамгаалах; 2/Боловсрол, шинжлэх ухаан, соёлын; ...”. Мөн зүйлийн 5-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны дотор дэд хороо байгуулж болно. Дэд хороо нь харьяалах Байнгын хорооныхоо үйл ажиллагааны тодорхой чиглэлийг эрхлэн хариуцаж, туслах үүрэгтэй.

1997 оны 02 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж, 12 дугаар зүйлийн 1-д “Байнгын хороо нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.”, 2-т Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:” гээд 7 Байнгын хороог нэрлэн заасан. Тухайлбал, 1.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 2.Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн; ...” гэж, мөн зүйлийн 15 дугаар зүйлд Дэд хороо /АБГБХ-Тусгай хяналтын, ТББХ-Ёс зүйн, Нутгийн өөрөө удирдах ёсны,.../ түүний эрхлэх асуудлын хүрээг хуульчилсан байх бөгөөд энэ зүйлийн 2-т “Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.” гэж тусгажээ.

2001 оны 06 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.” гэж, 16 дугаар зүйлийн 16.2-т Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:” гээд 11 Байнгын хороог нэрлэн заасан байна. Тухайлбал, “16.2.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 16.2.2.Байгаль орчны; ...”, мөн хуулийн 19 дүгээр зүйлд 5 Байнгын хороонд 6 дэд хороо /АБГБХ-Тусгай хяналтын, ТББХ-Ёс зүйн, Нутгийн өөрөө удирдах ёсны .../-г харьяалуулж, 19.2 дахь хэсгээр Улсын Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.” гэж тусгажээ.

2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Байнгын хороог төрийн бодлогын салбар, чиглэлээр гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:” гээд 8 Байнгын хороог нэрлэн зааж /19.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 19.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн/, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг мөн зүйлээр зохицуулсан байна. Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт 7 Байнгын хорооны бүрэлдэхүүнд 10 дэд хороог байгуулахаар тусгасан бөгөөд 24.1.7-д “Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаарын бохирдлыг бууруулах асуудлын.” гэж, 24.3.11 дэх заалтад “Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаархи хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг.” эрхлэнэ гэж заажээ.

2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна:” гээд 11 Байнгын хороог нэрлэн зааж /23.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын;

23.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;/, 24 дүгээр зүйлээр Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээг заасан байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт 7 Байнгын хорооны бүрэлдэхүүнд 11 дэд хороо байгуулж болохоор тусгасан байх бөгөөд 28.1.2 дахь заалтад “Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаарын бохирдлыг бууруулах асуудлын;” гэж, 28.2.1 дэх заалтад “Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;” эрхлэнэ гэж заажээ.

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д “Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна.” гээд 11 Байнгын хороог нэрлэн зааж /22.6.1.Аж үйлдвэржилтийн бодлогын; 22.6.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 22.6.3.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн; .../ 23 дугаар зүйлээр Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ, 27 дугаар зүйлээр Дэд хорооны асуудлыг хуульчилсан байна. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болно” гэж, 27.3-т “Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна.” гээд 5 Байнгын хорооны бүрэлдэхүүнд 5 дэд хороог байгуулахаар заажээ. /27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын; 27.3.2.Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын; ... /

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд орсон он оны өөрчлөлтөөс үзэхэд 1992 оны хуульд Байгаль орчныг хамгаалах Байнгын хороо, түүний тусгай чиг үүргийг Улсын Их Хурлын 1993 оны 73 дугаар тогтоолоор заасан байх бөгөөд тогтоолын хавсралтын 9 дүгээр зүйлийн 1-д “газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;” гэж, 3-т “байгаль орчин, тогтвортой хөгжил байгалийн тэнцэл” гэж, 1997 оны хуульд Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд “... байгаль орчны төрийн хяналт, агаарын бохирдол, хорт бодис байгаль орчны асуудал, байгаль орчны бодлого” гэж, 2001 оны хуульд Байгаль орчны Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд “...байгаль орчны хяналт, агаарын бохирдол, хорт бодис байгаль орчны асуудал, байгаль орчны бодлого,” гэж тусгаж, Байнгын хороо дээрх асуудлаар хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэйгээр ажиллахаар тус тус заасан байна.

Харин 2006, 2020 оны хуульд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд “... агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал; цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт” гэж тусгасан байх бөгөөд Байнгын хорооны бүрэлдэхүүнд Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороог хуулиар харьяалуулж, Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж, санал, дүгнэлтээ гаргах, харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар асуудлаа хэлэлцүүлэх, хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй байхаар хуульчилжээ.

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг хариуцахаар хуульд тусгасан байна.

2024 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд "... агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал; цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт" гэж тусгасан байх хэдий ч Агаарын бохирдлыг бууруулах дэд хороог хуулиар харьяалуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо шинэчилсэн найруулгад тусаагүй талаарх үндэслэл, судалгаа, мэдээлэл хуулийн хувийн хэрэгт дурдагдаагүй байна.

Хуулийн зохицуулалтаас дүгнэвэл үе үеийн Улсын Их Хурал агаар орчны бохирдолд анхааран зөв бодлого, шийдвэр гаргах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуулийн биелэлтэд хяналт тавих, хариуцлага тооцох асуудлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцдэг байсан байна.

Агаарын чанарыг сайжруулахаар 2011 оноос хойш Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд хоёр удаа (2011, 2012), Ерөнхий сайдын дэргэд (2013, 2015, 2017), БОНХАЖ-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд (2014) хөтөлбөрийг дагаж Ерөнхий сайдын дэргэд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог 2017 онд байгуулж ажиллаж байгаад, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 396 дугаар тогтоолоор Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Засаг даргад шилжүүлжээ.

2010-2017 оны хугацааны төсөв, зардлын тооцооллоор агаарын бохирдолтой холбоотой эдийн засгийн зардал 645.1 сая ам.доллар, агаарын бохирдолтой холбоотой халамжийн зардал 485.9 сая ам.доллар зарцуулсан байна¹. Агаарын бохирдлын эсрэг арга хэмжээнд 2008–2018 онд улсын төсвөөс 147.3 тэрбум төгрөг, 60.7 сая ам. доллартой тэнцэх хэмжээний гадаадын зээл тусламжийн хөрөнгийг зарцуулжээ.² Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017–2020 оны хугацаанд нийт 456.1 тэрбум төгрөг зарцуулжээ³. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг <https://open.audit.mn/report> холбоосоор орж танилцаж болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нарийвчлан зохицуулсан 30 хууль тогтоомж, 200 эрх зүйн акт, стандартын давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох судалгаа, дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн байх бөгөөд Үүнд: "Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актын дүн шинжилгээний үр дүнд давхардал 16,

¹ <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/infographics-mon.pdf>

² ААРС/НҮБХХ, 2019. Монгол Улсын агаарын бохирдол: Цаашдын арга зам, боломжууд–
<https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/air-pollution-in-mongolia-opportunities-for-further-actions.html>

³ Үндэсний аудитын газар, Аудитын тайлан, Агаар орчны бохирдолтой холбоотой төсвийн орлогыг бүрэн төлөвлөж, бүрдүүлээгүй, зарим бараа, ажил үйлчилгээг төрийн нууцад хамааруулан шууд гэрээгээр худалдан авсан байна. 2021 он

зөрчил 29, хийдэл 71 байгааг тодорхойлж, агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, түүний харьяа байгууллагаас давхардсан шинжтэй хэд хэдэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол гарсан гэж дурдсан байна.

Түүнчлэн Нийслэл, дүүрэг, хорооны Засаг дарга, Үндэсний хороо зэрэг байгууллага, албан тушаалтан, тэдгээрээс байгуулагдсан ажлын хэсгээс акт гарган хэрэгжүүлж байгаа талаар дурджээ. Тухайлбал, Үндэсний хорооны харьяалах дээд байгууллага, институт нь хууль тогтоомжоор өөрчлөгдөх бүрийд өөрийн эрх хэмжээний хүрээнд тогтоол, шийдвэр, Нийслэлийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зэрэг байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ өөрчлөгдөн батлагддаг жишиг тогтож, агаарын орчны бохирдлыг бууруулахад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд үр дүнгүй, гацаанд орсоор өнөөдрийг хүрчээ.

Эрдэм шинжилгээний байгууллагуудаас гаргасан судалгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдол нь амьсгалын замын өвчлөл, уушигны хавдар, уушги, зүрх-уушгины хавсарсан өвчний шалтгаант нас баралтын голлох шалтгаан болж байгааг тогтоож, Монгол Улс агаарын бохирдолд анхаарал хандуулж шат шатандаа холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч агаарын бохирдол буураагүй, чанарт тодорхой өөрчлөлт ороогүй хэвээр байгаа бөгөөд агаарын бохирдол нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна сүүлийн жилүүдэд ус, хөрсний бохирдол ч мөн адил хэмжээний хор хохирол, сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар холбогдох судалгааны дүгнэлтүүд гарсаар байна.

Монгол Улсад агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулж, бодит үр дүнд хүрэх стратегийг хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг дэмжих орчныг бүрдүүлэх нэн шаардлагатай байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэж буй үр дагавартай холбоотой хүний эрхийн асуудал хөндөгдөж, хүний эрхэд суурилсан уур амьсгалын эрх зүйн зохицуулалт, бодлого, арга хэмжээ авах шаардлага үүсэж байгаа билээ.

Мөн Монгол Улс НҮБ-аас батлан гаргасан олон улсын эрх зүйн хэм хэмжээнээс 10 гаруй олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон байх бөгөөд тухайлбал, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Биологийн олон янз байдлын тухай НҮБ-ын суурь конвенц, Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенц, Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц зэрэг.

Дээр дурдсан асуудлуудын хүрээнд Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэх, үндэсний хууль тогтоомжийн нарийн зохицуулалт, уялдааг хангах, цаашид агаар орчны бохирдлыг бууруулах, хүнийг эрүүл, аюулгүй орчинд амьдруулах арга хэмжээний төлөвлөгөөг урт хугацаанд тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагад оруулж, үйл ажиллагааны үр дүнтэй тухай бүр танилцах, хянах, үнэлэх, хариуцлага тооцох тогтолцоог тодорхой болгох үүднээс Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах “агаарын бохирдол, хорт бодис, цаг уур, орчны хяналтын, усны бодлого, нөөц, усны

бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалтын” асуудалтай холбогдох хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороог байгуулах шаардлагатай гэж хууль санаачлагч үзлээ.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюлгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг ханган, баталгаажуулах зорилгоор улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Агаар, орчны бохирдлын дэд хороог Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны харьяанд байгуулах зохицуулалтыг хуульчилна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд 27.3.2 дахь заалт нэмэгдэнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр дүнд гарч байгаа хууль тогтоомж, бусад шийдвэр оновчтой болох, тухайн салбар, чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, тулгарч буй асуудалд тухай бүр дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчин сайжрах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоожмийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэх, ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үндэснийхээ эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчимд нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагалдан боловсруулах төсөлгүй болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хоринтавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”, Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасныг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажиллана.” гэж, 22.3 дахь хэсэгт Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээний бүрэн эрхийг, 22.6 дахь хэсэгт Улсын Их Хурлын 11 Байнгын хороог, мөн хуулийн 23 дугаар зүйлээр Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээг заасан байх бөгөөд 2006, 2020 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд туссан Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо буюу Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороог 2024 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуульд тусгаагүй талаарх шалтгаан, нөхцөл тодорхойгүй байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т заасны дагуу 70,000 ба түүнээс дээш тооны иргэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах санал гаргаж, хуульд заасан журмын дагуу шаардлага, нөхцөл хангагдсан тул Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2025 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдөр зохион байгуулж, санал, дүгнэлтээ 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн БОХХААБХ-нд, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы Нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүнэлтэд “Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид утаа, агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулж, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, хянан шалгах эрх бүхий байгууллагын мэдээллийг тогтмол сонсох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг

шийдвэрлэх” гэж тусгасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулж, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нарийвчлан зохицуулсан 30 хууль тогтоомж, 200 эрх зүйн акт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, түүний харьяа байгууллагаас нилээдгүй төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна.

Агаар орчны бохирдлын асуудлыг төрийн бүх байгууллага, нийслэл, орон нутгийн байгууллага, бусад эрдэм шинжилгээний болон судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн чиг үүргийн дагуу хариуцан гүйцэтгэж байна.

Гэвч агаар орчны бохирдлыг бууруулахтай холбоотой хууль тогтоомж, шийдвэрийн уялдааг хангах, зөрчлийг арилгах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил төдийлөн хийгдээгүй талаарх судалгааны дүгнэлтүүд гарсаар байна.

Энэ нь хууль тогтоох дээд байгууллагын хувьд батлагдан гарсан хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт сул, хяналт, шалгалтын ажил хийгдсэн ч төдийлөн оновчтой, үр дүнтэй бус байгаагийн нэг илрэл гэж дүгнэж болохоор байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг ханган, баталгаажуулах зорилгоор Монгол Улсад агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулж, бодит үр дүнд хүрэх стратегийг хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг дэмжих орчныг бүрдүүлэхийн тулд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны харьяанд “агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал, цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт” зэрэг асуудлыг дагнан хариуцах үүрэг бүхий “Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хороог байгуулах хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт:

“27.3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар орчны бохирдлын;”

2/27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалт:

“27.5.1. Агаар орчны бохирдлын дэд хороо улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх бодлого, зохицуулалтын болон хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2, 27.3.3, 27.3.4, 27.3.5 дахь заалтын дугаарыг “27.3.3, 27.3.4, 27.3.5, 27.3.6” гэж, мөн зүйлийн 27.5.1, 27.5.2, 27.5.3, 27.5.4, 27.5.5 дахь заалтын дугаарыг “27.5.2, 27.5.3, 27.5.4, 27.5.5, 27.5.6” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг